

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/223-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-2442	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Б.Наранцэцэг Цахим хаяг: narantsetsegba@audit.gov.mn
Сүхбаатар сум 2023 он		

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. Аудитын тайлан	15-17
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20-21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.БАТБААТАР ТАНАА

2023.02.14 № СЭА-2023/223-НА-СТА-ТШЗ
таныг _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 94.0 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлсний зардлыг 6.2 хувиар, НДШ-ийн зардлыг 4.3 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 13.5 хувиар тус тус хэмнэснээс шалтгаалж, нийт төсөв 6.0 хувиар хэмнэгдсэн байна.

Тайлант онд ҮСХ-оос 80,000.0 мянган төгрөгийн Сузуки Жимни маркын суудлын автомашин, 31,584.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,020.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил зэрэг нийт 115,604.9 мянган төгрөгийн хөрөнгийг балансасан балансад шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 97.1 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд уг зардалд нийт 104,087.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд 10 жил тутамд 1 удаа хийгддэг хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг зохион байгуулахад зориулсан 104,996.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,170,488.31	3,398,415.00
33	АВЛАГА	67,273.31	0
33500	Бусад авлага	67,273.31	0
33510	Байгууллагаас авах авлага	67,273.31	0
35	БАРАА МАТЕРИАЛ	3,103,215.00	3,398,415.00
35100	Түүхий эд материал	110,000.00	110,000.00
35110	Тусгай зориулалттай материал	110,000.00	110,000.00
35400	Хангамжийн материал	2,993,215.00	3,288,415.00
35420	Аж ахуйн материал	2,993,215.00	3,288,415.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	42,195,295.76	141,088,252.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	42,195,295.76	141,088,252.39
39200	Биет хөрөнгө	42,195,295.76	141,088,252.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,000,000.00	117,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-37,000,000.00	-41,000,000.02
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	71,027,303.44	96,023,291.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,635,407.68	-36,543,658.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,692,154.00	12,712,154.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,888,754.00	-7,103,534.85
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	45,365,784.07	144,486,667.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	45,365,784.07	144,486,667.39
51	Засгийн газрын хувь оролцоо	45,365,784.07	144,486,667.39
51200	Хуримтлагдсан үр дүн	45,365,784.07	144,486,667.39
51210	Өмнөх үеийн үр дүн	46,611,712.24	45,365,784.07
51220	Тайлант үеийн үр дүн	-1,245,928.17	99,120,883.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	45,365,784.07	144,486,667.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	248,463,760.68	484,420,230.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,251,505.68	114,943,007.15
120	Нийтлэг татварын бус орлого	10,251,505.68	114,943,007.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,141,505.68	0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,141,505.68	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.0	114,647,807.15
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	110,000.00	295,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	238,212,255.00	369,477,223.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	112,386,400.00	114,063,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	112,386,400.00	114,063,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	125,825,855.00	255,413,923.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,305,800.00	7,497,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,166,121.00	246,472,057.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,353,934.00	1,444,866.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	249,709,688.85	385,299,346.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	249,709,688.85	385,299,346.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	248,964,480.45	378,019,150.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,768,369.94	92,306,001.93
210101	Үндсэн цалин	69,028,114.92	70,702,584.37
210102	Нэмэгдэл	20,748,206.20	12,587,998.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,927,530.14	3,134,999.56
210104	Урамшуулал	7,064,518.68	5,880,420.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,168,452.35	11,848,714.48
210201	Тэтгэврийн даатгал	9,466,166.74	8,103,177.93
210202	Тэтгэмжийн даатгал	896,531.23	949,803.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	806,338.36	750,501.60
210204	Ажилгүйдлийн даатгал	195,940.48	185,760.66
210205	Эрүүл мэндийн даатгал	1,803,475.54	1,859,471.10
2104	Хангамж, бараа материалын зардал	4,266,800.00	3,004,801.15
210401	Бичиг хэрэг	2,800,696.00	1,590,456.00
210402	Тээвэр, шатахуун	718,200.00	603,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	515,104.00	440,345.15
210404	Ном, хэвлэл	232,800.00	370,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,110,000.00	104,200.00
210604	Урсгал засвар	3,110,000.00	104,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	111,432,651.00	254,745,482.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,766,351.00	252,436,382.00
210803	Даатгалын үйлчилгээ	247,500.00	247,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,295,600.00	1,938,400.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,218,207.16	16,009,950.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,401,500.00	255,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,816,707.16	15,754,850.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	745,208.40	7,280,196.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	244,000.00	431,714,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	501,208.40	7,080,196.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	457,274.40	6,865,521.75
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	43,934.00	214,675.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,245,928.17	99,120,883.32
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,245,928.17	99,120,883.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	238,212,255.00	369,477,223.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	238,212,255.00	369,477,223.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	112,386,400.00	114,063,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	112,386,400.00	114,063,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	125,825,855.00	255,413,923.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,305,800.00	7,497,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,166,121.00	246,472,057.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,353,934.00	1,444,866.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	238,212,255.00	369,477,223.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,212,255.00	369,477,223.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	237,467,046.60	362,197,026.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,666,870.89	92,306,001.93
210101	Үндсэн цалин	62,328,565.87	70,702,584.37
210102	Нэмэгдэл	22,005,756.20	12,587,998.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,927,530.14	3,134,999.56
210104	Урамшуулал	7,405,018.68	5,880,420.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,501,054.71	11,781,441.17
210201	Тэтгэврийн даатгал	8,728,130.79	8,035,904.62
210202	Тэтгэмжийн даатгал	974,501.72	949,803.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	762,801.26	750,501.60
210204	Ажилгүйдлийн даатгал	185,056.54	185,760.66
210205	Эрүүл мэндийн даатгал	1,850,564.40	1,859,471.10
2104	Хангамж, бараа материалын зардал	4,474,800.00	3,004,801.15
210401	Бичиг хэрэг	2,789,300.00	1,588,966.00
210402	Тээвэр, шатахуун	718,200.00	603,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	526,500.00	441,835.15
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	440,800.00	370,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,124,000.00	104,200.00
210604	Урсгал засвар	3,124,000.00	104,200.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,298,821.00	254,745,482.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,582,521.00	252,436,382.00
210803	Даатгалын үйлчилгээ	247,500.00	247,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,345,600.00	1,938,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,401,500.00	255,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,401,500.00	255,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	745,208.40	7,280,196.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	244,000.00	200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	501,208.40	7,080,196.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	457,274.40	6,865,521.75
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	43,934.00	214,675.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	46,611,712.24	46,611,712.24
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	46,611,712.24	46,611,712.24
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-1,245,928.17	-1,245,928.17
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	45,365,784.07	45,365,784.07
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	45,365,784.07	45,365,784.07
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	45,365,784.07	45,365,784.07
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	99,120,883.32	99,120,883.32
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	144,486,667.39	144,486,667.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	114,063,300.00	107,197,778.25	6,865,521.75	94.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	114,063,300.00	107,197,778.25	6,865,521.75	94.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	113,819,300.00	106,997,778.25	6,821,521.75	94.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,457,900.00	92,306,001.93	6,151,898.07	93.8
210101	Үндсэн цалин	69,514,400.00	70,702,584.37	-1,188,184.37	101.7
210102	Нэмэгдэл	18,524,400.00	12,587,998.00	5,936,402.00	68.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,342,400.00	3,134,999.56	2,207,400.44	58.7
210104	Урамшуулал	5,076,700.00	5,880,420.00	-803,720.00	115.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,307,300.00	11,781,441.17	525,858.83	95.7
210201	Тэтгэврийн даатгал	8,368,900.00	8,035,904.62	332,995.38	96.0
210202	Тэтгэмжийн даатгал	984,600.00	949,803.19	34,796.81	96.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	787,700.00	750,501.60	37,198.40	95.3
210204	Ажилгүйдлийн даатгал	196,900.00	185,760.66	11,139.34	94.3
210205	Эрүүл мэндийн даатгал	1,969,200.00	1,859,471.10	109,728.90	94.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,632,600.00	1,631,935.15	664.85	100.0
210401	Бичиг хэрэг	216,100.00	216,100.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	603,600.00	603,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	442,500.00	441,835.15	664.85	99.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	370,400.00	370,400.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	104,200.00	104,200.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	104,200.00	104,200.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,062,200.00	919,100.00	143,100.00	86.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	122,800.00	0	122,800.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	247,500.00	247,500.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64,300.00	44,000.00	20,300.00	68.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	548,400.00	548,400.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	255,100.00	255,100.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	255,100.00	255,100.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,000.00	200,000.00	44,000.00	82.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,000.00	200,000.00	44,000.00	82.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	244,000.00	200,000.00	44,000.00	82.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	114,063,300.00	107,197,778.25	6,865,521.75	94.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	114,063,300.00	107,197,778.25	6,865,521.75	94.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	114,063,300.00	107,197,778.25	6,865,521.75	94.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	255,413,923.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	255,413,923.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	255,199,248.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,372,866.00
210401	Бичиг хэрэг	1,372,866.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	253,826,382.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	252,436,382.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,390,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214,675.00
213	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	214,675.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	214,675.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	255,413,923.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,444,866.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,444,866.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	253,969,057.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,497,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	246,472,057.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь цаашид Статистикийн хэлтэс гэх/ "Монгол Улсын статистик мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.



Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг "Албан ёсны статистикийн бүртгэл хөтлөх, мэдээлэл гаргаж өгөх, дамжуулах, нэгтгэн боловсруулах, тооллого, судалгаа явуулах, дүгнэлт гаргах, мэдээлэл, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тархаах, хэвлэн нийтлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, сан байгуулах, хадгалах статистикийн бүх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахад чиглэгдэнэ." гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107, 05 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолоор "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ"-г шинэчлэн тогтоосон гэх мэт.


Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант хугацаанд Статистикийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны байгууллагаас дотоод хяналт шалгалт хийгдээгүй байгаа тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн

тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ҮСХ-ны даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/162 дугаар тушаалаар Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэлийн Статистикийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99,120.9 мянган төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	67.3	-	(67.3)
Бараа материал	3,103.2	3,398.4	295.2
Үндсэн хөрөнгө	42,195.3	141,088.3	98,893.0
Нийт хөрөнгө	45,365.9	144,486.7	99,120.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	45,365.8	144,486.7	99,120.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	45,365.8	144,486.7	99,120.9

Өмнөх оны эцэст НДШ-ийн 67.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант оны шимтгэлийн зардлаас суутган тооцож үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,398.4 мянган төгрөг болж 295.2 мянган төгрөгөөр өссөн нь ҮСХ-ноос 295.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ

210.6 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна/ төсвийн зохицуулалт хийсэн байна.



Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 114,063.3 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр 114,063.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 107,197.8 мянган төгрөг буюу 94.0 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 6,677.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	113,696.5	106,997.8	6,698.7	94.1
2	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	122.8	-	122.8	-
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	244.0	200.0	44.0	81.9
	Дүн	114,063.3	107,197.8	6,865.5	94.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130026401 тоот дансанд ҮСХ-ноос 246,472.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 7,497.0 мянган төгрөг, статистикийн эмхэтгэл борлуулсны 1,444.9 мянган төгрөг зэрэг нийт 255,413.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 255,199.2 мянган төгрөгийн дараах зардлуудад зориулалтын дагуу зарцуулан 214.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэргийн зардалд 1,372.8 мянган төгрөг,
- Улсын мэдээллийн маягт хэвлэх зардалд 1,390.0 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 252,436.4 мянган төгрөг зэрэг.

Нэмэлт төсвийн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 249,847.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,747.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах хэмнэлтийг хийж ажилласан байна. Үүнд:

- Эрдэм шинжилгээний судалгааны ажлыг цахимаар зохион байгуулж холбогдох зардлыг 122.8 мянган төгрөгөөр,
- Танхимаар зохион байгуулах хөдөлмөрийн статистикийн аргачлалын сургалтыг цуцалж, хөдөлмөрийн судалгааны зардлын санхүүжилтэд суутган тооцуулж 1,660.0 мянган төгрөгөөр тухайн зардлуудыг тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Статистикийн хэлтэс нь мэдээлбэл зохих 27 нэр төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар шатахууны шаардах хуудас болон замын маршрут зэргийг баталсан, хүлээн авсан албан хаагчийн гарын үсэггүйгээр буюу анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн зөрчил илэрч асуудлын бүртгэлээр зөвлөмж өгч аудитын явцад шатахууны шаардах хуудас болон замын маршрут зэргийн бүрдлийг хангуулав.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-гүйгээр илүү цагийн хөлс тооцож, олгосон, жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтаар хөтлөөгүй, шатахууны тооцоог шатахуун зарцуулсан албан хаагчийн гарын үсгээр баталгаажуулаагүй болон шилэн дансанд мэдээлбэл зохих 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчилд 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт


/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	3,979.8	3	3,979.8	100.0
Нийт дүн	3	3,979.8	3	3,979.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Статистикийн хэлтсийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

Дээд шатны төсвийн захирагчийн буюу Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг шинэчлэн батлах тухай” А/122 дугаар тушаалаар тус хэлтсийн нягтлан бодогчийн цалингийн шатлалыг ТҮ-7 буюу 1,066.5 мянган төгрөгөөр /ТҮ-7 цалингийн шатлал 766,481/, зохион байгуулагч албан тушаалын цалингийн шатлалыг ТҮ-6 буюу 1,009.7 мянган төгрөгөөр /ТҮ-6 цалингийн шатлал 709,759/ тус тус шинэчлэн 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохоор баталсны дагуу үндсэн цалинг тооцож, олгосон байна.



5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 148,893.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Харилцагчдын нэр, тооцоог зөрүүтэй илэрхийлснээс өр төлбөр дансны дэлгэрэнгүй тайлан үлдэгдлээс 33,950.9 мянган төгрөгөөр зөрсөн.
- Дээд шатны төсвийн захирагчаас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгсөн 114,647.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 295.2 мянган төгрөгийн бараа материалын орлогыг дансны ангилал буруу бүртгэсэн.
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл э-тайлангаас зөрүүтэй тайлагнагдсан.

Аудитаар нийт 609.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 609.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Судалгааны ажлаар сумдад ажилласан 3 албан хаагчид нийт 609.5 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон албан томилолтын зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 25 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.



5.3.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын зарлагын баримт, шаардах хуудсанд түүнийг үйлдсэн, хүлээн авсан болон зөвшөөрсөн ажилтны гарын үсэг дутуу, тамга, тэмдгээр баталгаажуулаагүй зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7 дэх "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

5.3.3 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрч буй 22 төрлийн судалгааны ажилд зарцуулагдах цалин, унаа хоолны хөнгөлөлт, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, албан томилолт, шатахуун, сургалт зэрэг зардлуудыг тус тусын зардлын ангилалд бус бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, хянах зарчмыг алдагдуулж байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрч буй санхүүжилтийн зарцуулалтын эрхийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ



Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлийг зөрүүтэй илэрхийлсэн	1	33,950.9			1	33,950.9	1	33,950.9				
Дансны ангилал буруу бүртгэсэн	1	114,943.0			1	114,943.0	1	114,943.0				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн	1				1		1					
Дүн	3	148,893.9			3	148,893.9	3	148,893.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан томилолтын зардлыг илүү олгосон.	1	609.5	1	609.5								
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 25 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй.	1						1					
Анхан шатны баримын бүрдэл дутуугаар ажил гүйлгээг бүртгэсэн.	1						1					
Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг зардлын бүлэг, зүйл бүрээр тайлагнаагүй.	1						1					
Дүн	4	609.5	1	609.5			3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/



Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								